

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|   |     |
|---|-----|
| 1. Аудитын гэрчилгээ .....  | 2   |
| 2. Аудитын тайлан.....  | 4   |
| 2.1. Оршил.....   | 4   |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....  | 4   |
| 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....  | 4   |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....  | 5   |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 5   |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....   | 6   |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....  | 6   |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....   | 6   |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....  | 7   |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....   | 7   |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....  | 8   |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл .....   | 8   |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....  | 8   |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....   | 8   |
| 3. Менежментийн захидал.....  | 10  |
| 3.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал.....   | 10  |
| 3.2. Зардлын данстай холбоотой асуудал.....   | 10  |
| 3.3. Зардлын данстай холбоотой асуудал.....   | 11  |
| 3.4. Шилэн данстай холбоотой асуудал .....  | 11  |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....  | 13  |
| 4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....   | 13  |
| 4.2. Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан .....  | 14  |
| 4.3. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан .....  | 16  |
| 4.4. Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан.....  | 18  |
| 4.5. Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....  | 19  |
| 4.6. Аудит хийсэн Нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан.....  | 219 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....   | 22  |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС   | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт               |
| АОУС     | Аудитын олон улсын стандарт                                 |



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/562  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дүрслэх урлагийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дүрслэх урлагийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дүрслэх урлагийн музейн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дүрслэх урлагийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дүрслэх урлагийн музейн захирал У.Сарантуяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, зардлын бүртгэл, тайлагнал, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дүрслэх урлагийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүрслэх урлагийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Мишээл-Од Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дүрслэх урлагийн музей нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 8 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дүрслэх урлагийн музейн эрхэм зорилго нь "Монголын дүрслэх урлагийн зууны шилдэг зураач, урчуудын бүтээл туурвилын сор, дахин давтагдашгүй үзмэрүүдийг дотоод гадаадын үзэгчдэд дэлгэн толилуулж, судалгааны гүнзгий үндэслэлтэйгээр тайлбарлан таниулахын зэрэгцээ хадгалан хамгаалах ажлыг мэргэжлийн өндөр түвшинд эрхэлдэг, үндэсний соёл урлагийн эрхэмсэг байгууллага байх"-д оршино.

Дүрслэх урлагийн музей нь 1966 онд анх үүсгэн байгуулагдаж 300 гаруй үзмэртэй нээгдсэн бол одоогийн байдлаар 16809 нэгж бүхий сан хөмрөгтэй, 12 танхимтай үйл ажиллагаагаа явуулж байна. 1995 онд уг музейг Г.Занабазарын нэрэмжит болгосон байна.

Дүрслэх урлагийн музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- 2009 онд батлагдсан Улс, орон нутгийн музейн дүрмийн 1.2-д Музей нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, сургах, таашаал хүртээх зорилгоор хүн түүний орчинтой холбоотой бодит ба бодит бус байгаль, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, харилцан холбох байнгын үйл ажиллагаа бүхий ашгийн төлөө бус, олон нийтэд нээлттэй байгууллага байх;
- Музей, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, арвижуулах ажиллагаа.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолоор "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам", "Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам";
- Засгийн газрын 2019 оны 5 тоот тогтоолоор "Төрийн албан хаагчид шагнал олгох журам", "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан, хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт", "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам";
- Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор баталсан "Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл";
- "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалаар баталсан.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус музейн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр

батлагдсан бодлого, журамд нийцсэн байгаа боловч тухайн байгууллагын гол хөрөнгө болох түүх соёлын үнэт зүйлийг хэрхэн бүртгэх, тайлагнах талаар бодлого, дүрэм журам тусгагдаагүй.

Дүрслэх урлагийн музей нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “ACOLOUS 3.0” програм хангамж ашигладаг байна.

Дүрслэх урлагийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дүрслэх урлагийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны гуравдугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 400,416.4 мянган төгрөгөөс тооцон 8,008.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож түүний 2 хувь буюу 12,780.9 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тогтоосон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дүрслэх урлагийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 73,700.5 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, биет хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

|  | /мянган төгрөгөөр/  |                     |                  |
|--|---------------------|---------------------|------------------|
| Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт         |
| Б  | 1                   | 2                   | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                                       |                     |                     | -                |
| Авлага   | 14,594.0            | 24,888.1            | 10,294.1         |
| Бараа материал                                       | 77,415.7            | 80,643.5            | 3,227.8          |
| Биет хөрөнгө   | 27,874,792.9        | 27,786,783.0        | -88,009.9        |
| Биет бус хөрөнгө                                     | 86,843.2            | 87,630.7            | 787.5            |
| <b>Нийт хөрөнгө</b>                                  | <b>28,053,645.8</b> | <b>27,979,945.3</b> | <b>-73,700.5</b> |
| Өр төлбөр  |                     | 180.0               | 180.0            |
| Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/ | 2,372,812.2         | 2,372,812.2         | -                |
| Хуримтлагдсан үр дүн                                 | -53,480.7           | -127,361.2          | -73,880.5        |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                     | 25,734,314.3        | 25,734,314.3        | -                |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>    | <b>28,053,645.8</b> | <b>27,979,945.3</b> | <b>-73,700.5</b> |



Авлагын дансны үлдэгдэл 10,294.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны эхний үлдэгдэл 14,594.0 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан боловч тайлант оны эцсийн байдлаар 8 харилцагчтай холбоотой 24,888.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Эдгээрийн 6 харилцагчийн гэрээт ажлын хугацаа дуусаагүй, 2 харилцагч нь ажилтан, албан хаагчид урьдчилгаа өгсөнтэй холбоотой ба гэрээ дүгнэсэн актаар баталгаажсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,227.8 мянган төгрөгөөр өссөн нь музейн үйл ажиллагаа, түүхийг сурталчлах зорилгоор ном тараах материал хэвлүүлсэнтэй холбоотой байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 0.4 хувь буюу 88,009.9 мянган төгрөгөөр буурсан нь 20,268.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч 107,490.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн данс 73,880.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тус музейн санхүүгийн үр дүн 73,880.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дүрслэх урлагийн музей тайлант онд 120,577.7 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлсэн бөгөөд тус орлого нь төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл урлагийн хөтөлбөрт зориулан 460,076.9 мянган төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсанаас 444,388.1 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, 413,211.6 мянган төгрөгийг зарцуулж 31,176.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 120,783.1 мянган төгрөгийг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг үндэслэн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 120,577.7 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 205.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 129,372.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,349.8 мянган төгрөгийн алдааг залруулж, төлөвлөгөөнд тусгагдаагүй орлогын 120,577.7 мянган төгрөгийн алдаа нь тухайн байгууллагын үйл ажиллагаанаас хамаарахгүй байгаа тул цаашид анхаарах асуудалд тусган зөвлөмж өгсөн, 4,237.5 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 2,207.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар мөнгөн гүйлгээний тайланд мэдээлэл технологийн үйлчилгээнд төлсөн 2,349.8 мянган төгрөгийн гүйлгээг урсгал шилжүүлгийн ангилалд оруулан бүртгэснийг залруулсан.

Аудитаар залруулагдаагүй нийт 4,237.6 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:



1. Засгийн газрын тогтоолоор баталсан үндсэн цалингийн хэмжээг зөрүүтэй тогтоосноос 1 ажилтанд 1,722.1 мянган төгрөгийг илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 8 дугаар хавсралтаар батлагдсан Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг баримтлаагүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-д заасан ур чадварын нэмэгдэл олгох дээд хязгаараас давуулан нийт 6 ажилтанд 2,515.4 мянган төгрөгийг илүү олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 2,207.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тус музейн билетийн орлогын бүртгэл, тайлагнал болон үйл ажиллагааны орлогыг 2020 оны батлагдсан төсөвт тусгаагүй байгаа тул гол анхаарах асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн тайлант онд ур чадварын нэмэгдлийг бүх ажиллагсад олгож байгаагаас гадна Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолд ур чадварын нэмэгдэл олгох дээд хязгаарыг 25.0 хувиар тогтоосон байхад түүнээс өндөр хувиар олгож байгааг 2020 онд залруулан ур чадварын нэмэгдэл олгох журам боловсруулан, тогтоолыг мөрдөж байгаа эсэхийг дараагийн аудитаар дахин хянах нь зүйтэй гэж үзлээ.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дүрслэх урлагийн музей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 108 мэдээллийг хугацаанд нь, 37 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 454.8 мянган төгрөгийн 1 албан төлбөрийн акт тогтоосныг хугацаанд нь хэрэгжүүлсэн.

Нийт 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дүрслэх урлагийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 6,444.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 12,780.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дүрслэх урлагийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Дүрслэх урлагийн музей нь тайлант онд 120,783.1 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлсэн бөгөөд тус орлого нь төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4-т "Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно", 3.4.3-т "Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Төсвийн төлөвлөгөөг үндэслэлгүй батлуулах, үргүй зардал гаргах

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, дээд шатны байгууллагаар батлуулан, үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөнд тусгахгүй орхигдуулсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Яамнаас гарах шийдвэрт үндэслэн 2020 онд алдааг залруулна.

#### **3.2. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1. Илрүүлэлт:**

Шатахууны зардлыг тооцохдоо жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, жишиг нормын дагуу тооцоогүйгээс 840.9 мянган төгрөгийн шатахуун илүү олгосон.

Энэ нь тайлант онд мөрдөгдөж байсан Монгол улсын дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад тусгагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-той нийцэхгүй байна.

### **3.2.2. Эрсдэл:**

Батлагдсан төсөв хэтрээгүй боловч Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчих;

### **3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ын дагуу шатахууны тооцоог үнэн зөв тооцох

### **3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Тээвэр шатахууны тооцоог баталсан нормын дагуу бодон тооцож ажиллана.

## **3.3. Зардлын данстай холбоотой асуудал**

### **3.3.1. Илрүүлэлт:**

Ээлжийн амралтын тооцоог давтан тооцоход 5 ажилтанд 334.8 мянган төгрөгийг илүү олгосон, 8 ажилтанд 1,031.6 мянган төгрөгийг дутуу олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т “үнэн зөв байх”, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 15-д “Ажилтан ажлаас халагдах үед ажил олгогч нь түүнтэй ээлжийн амралтын тооцоог заавал хийнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### **3.3.2. Эрсдэл:**

Цалин хөлс, шагнал урамшуулал болон ээлжийн амралтын тооцоог илүү, дутуу тооцож олгосон байх;

### **3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Ээлжийн амралтын тооцоог холбогдох журмын дагуу үнэн зөв тооцож олгох

### **3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Ээлжийн амралтын тооцоог журмын дагуу үнэн зөв тооцож ажиллана.

## **3.4 Шилэн данстай холбоотой асуудал**

### **3.4.1 Илрүүлэлт:**

Дүрслэх урлагийн музей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 108 мэдээллийг хугацаанд нь, 37 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **3.4.2 Эрсдэл:**

Шилэн дансны тухай хуулийг зөрчих;

#### **3.4.3 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заасан хугацаанд байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

#### **3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл           | Эцсийн үлдэгдэл          |
|------------|---|--------------------------|--------------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>92,009,695.00</b>     | <b>105,531,668.70</b>    |
| <b>31</b>  | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | 00.00                    | 00.00                    |
| <b>33</b>  | <b>АВЛАГА</b>   | 14,594,000.00            | 24,888,100.00            |
| 33100      | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 00.00                    | 1,929,780.00             |
| <b>335</b> | <b>Бусад авлага</b>   | 14,594,000.00            | 22,958,320.00            |
| 3351       | Байгууллагаас авах авлага   | 14,594,000.00            | 22,958,320.00            |
| <b>34</b>  | <b>УРЬДЧИЛГАА</b>   | 00.00                    | 00.00                    |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 77,415,695.00            | 80,643,568.70            |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>  | 77,415,695.00            | 80,643,568.70            |
| 35410      | Бичиг хэргийн материал  | 1,337,117.00             | 1,659,275.00             |
| 35420      | Аж ахуйн материал   | 37,924,895.00            | 44,719,751.00            |
| 35440      | Түлш, шатах тослох материал   | 379,890.00               | 1,195,420.00             |
| 35450      | Барилгын засварын материал  | 2,964,950.00             | 00.00                    |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 34,808,843.00            | 33,069,122.70            |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>27,961,636,054.61</b> | <b>27,874,413,671.56</b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 27,961,636,054.61        | 27,874,413,671.56        |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>   | 27,874,792,854.61        | 27,786,782,971.56        |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 1,014,405,900.00         | 1,014,405,900.00         |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | 00.00                    | -71,293,843.08           |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл  | 7,850,000.00             | 7,850,000.00             |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл   | -7,850,000.00            | -7,850,000.00            |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 210,009,185.15           | 223,655,863.15           |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | -163,646,421.54          | -194,304,813.04          |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 101,616,946.80           | 106,993,193.80           |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | -70,530,492.80           | -76,016,566.27           |
| 39213      | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс                                      | 26,773,960,500.00        | 26,773,960,500.00        |
| 39217      | Ном   | 8,977,237.00             | 9,382,737.00             |
| <b>393</b> | <b>Биет бус хөрөнгө</b>   | 86,843,200.00            | 87,630,700.00            |
| 39301      | Програм хангамж   | 385,000.00               | 1,225,000.00             |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл   | -385,000.00              | -437,500.00              |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 86,843,200.00            | 86,843,200.00            |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>28,053,645,749.61</b> | <b>27,979,945,340.26</b> |
| <b>4</b>   | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b>00.00</b>             | <b>180,000.00</b>        |
| <b>41</b>  | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 00.00                    | 180,000.00               |
| <b>413</b> | <b>Өглөг</b>  | 00.00                    | 180,000.00               |
| 41320      | Бараа үйлчилгээний зардлын өглөг                                      | 00.00                    | 180,000.00               |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>28,053,645,749.61</b> | <b>27,979,765,340.26</b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 28,053,645,749.61        | 27,979,765,340.26        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,372,812,225.00         | 2,372,812,225.00         |
| 51101      | Өмч: - төрийн   | 2,372,812,225.00         | 2,372,812,225.00         |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | -53,480,745.91           | -127,361,155.26          |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | -53,480,745.91           | -53,480,745.91           |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | 00.00                    | -73,880,409.35           |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 25,734,314,270.52        | 25,734,314,270.52        |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>28,053,645,749.61</b> | <b>27,979,945,340.26</b> |

#### 4.2. Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он              | Тайлант он            |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>659,917,308.00</b> | <b>565,164,147.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>312,248,848.00</b> | <b>88,891.00</b>      |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 312,248,848.00        | 88,891.00             |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 305,178,848.00        | 88,891.00             |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 103,289,494.00        | -                     |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | 201,889,354.00        | 88,891.00             |
| 120009      | Бусад орлого   | 7,070,000.00          | -                     |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>347,668,460.00</b> | <b>565,075,256.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | 306,766,400.00        | 444,388,100.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 306,766,400.00        | 444,388,100.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 40,902,060.00         | 120,687,156.00        |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,498,000.00         | -                     |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 28,404,060.00         | 120,687,156.00        |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>514,028,787.68</b> | <b>639,044,556.35</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>514,028,787.68</b> | <b>639,044,556.35</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 486,453,262.23        | 600,096,629.11        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 273,375,764.50        | 338,745,769.65        |
| 210101      | Үндсэн цалин   | 191,670,982.90        | 215,843,993.65        |
| 210102      | Нэмэгдэл   | 47,467,956.00         | 44,271,798.00         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 18,080,100.00         | 29,733,200.00         |
| 210104      | Урамшуулал   | 16,156,725.60         | 48,896,778.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 33,043,312.71         | 42,911,568.44         |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 22,135,714.17         | 26,226,839.55         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 3,122,086.54          | 8,841,877.64          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 2,124,305.00          | 1,913,830.00          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 512,692.00            | 314,721.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 5,148,515.00          | 5,614,300.25          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | 23,145,463.19         | 23,719,505.44         |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 11,244,775.80         | 12,494,396.03         |
| 210302      | Түлш, халаалт  | 11,069,248.00         | 10,196,939.36         |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 831,439.39            | 1,028,170.05          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 6,665,513.15          | 6,802,219.97          |
| 210401      | Бичиг хэрэг  | 872,904.00            | 1,263,415.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 1,619,620.00          | 968,344.00            |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 1,410,970.15          | 1,445,073.67          |
| 210404      | Ном, хэвлэл  | 104,900.00            | 117,200.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 1,711,765.00          | 1,752,168.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 945,354.00            | 1,256,019.30          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | 2,425,800.00          | 1,659,140.00          |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 2,425,800.00          | 1,659,140.00          |
